МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООГ ГАЛИГЛАХ ТУХАЙ АСУУДАЛД

Т.Дашцэдэн/БНМАУ/

Дундад зууны монгол хэлний цурсгалын зүйлд тэр цагийн монгол хэлний авианы байдал тусгагдсан байдлыг олон эрдэмтэн ажиглан тэмдэглэсэн нь цөөнгүй бий.

Дундад үеийн монгол хэлний цурсгалын зүйл үгүүржин монгол, цөрвөлжин үсэг, Хятадын цурс үсгээр тэмдэглэгдсэн байдаг болохоор тэдгээрийг харьцуулан судлах нь чухал юм.

Энэ талаар монголч эрдэмтэд их ажил хийв.Тэр үеийн бичгийн цурсгалын том бүтээлийн нэг болох "Монголын нууц товчоог" олон оронд янз бүрийн системийн галиг үсгээр буулган судалсан бийлээ.

Олон орны монголчдын хийсэн ба хийж буй судалгааны асар их ажлын ачаар дундад зууны үеийн монгол хэлний авианы байдлыг сэргээн босгоход багагүй ахиц гарч байгааг тэмдэглэлүүштэй санагдана.

Монголч нарын анхаарлыг их татаж буй зүйл бол дундад үеийн монгол бичгийн цурсгалын зүйлд арвин тохиолдлог

-ауа-; -ауа-, -ау а-, -оуо, -оуо-ду а-.uуа -, -eöü-.-öge-,-ögü-,-ügü-,-iуа-,-iуа-,iуu-,-igü-, -igi-,-iga-,ija-,ije-,

гэх мэтийн эгшиг-гийгүүлэгч-эгшгийн нийлбэр бөгөөд эдгээрийн байранд орчин цагийн монгол хэлэнд урт эгшиг байдаг.Дундад үеийн монгол хэлэнд урт эгшиг ерөөсөө байсан уу? эсвэл урт эгшиг бий болж байсан уу? гэдэг асуулт гарна.Энэ талаар монголч нар нэгдмэл саналтай байна гэхэд бэрхтэй.

1950-аад оны шувтарга хүртэл дундад үеийн монгол хэлэнд эгшиг-гийгүүлэг-эгшиг гэсэн нийлбэрийн цунадхь гийгүүлэгч сугаран гээгдэх замаар

урт эгшиг бий болсон гэж нийтлээ үзэж байсан бол Ш.Хаттори Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хурал дээр илтгэлээ сонирхолтой ажиглалт хийсэн юм.

Энэ нь чухамдаа -aγa-,-aγā-,ege-,-egē- гэсэн хоёр янз нийлбэр байгаад -aγa-,-ege- байсан нь орчин цагийн монгол хэлэнд урт эгшиг болоогүй, харин -aγā-, -egē- байсан газар дундахь гийгүүлэгч нь гээгдэж сүүлчийн урт эгшиг нь үлдсэн байна гэсэн санааг дэвшүүлэв.

Ш.Лувсанвандан уйгуржин монгол үсгийн болон дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлийг галиглах талаар бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэлүүддээ дундад үеийн Монгол хэлний урт богино эгшгийн талаар улам нарийн ажиглалт дүгнэлт хийсэн билээ.

Ер нь уйгуржин монгол бичгээр бичсэн зүйлийг дуудан унших нь эгшгийн урт богиныг нарийн ялгаж ирснийг жишээлж үзүүлбэл:
хуучин үсгээр дуудах нь

temege	temege	
bayatur	bayatur	
jabuγuluγad	jabuluγad	

Зохиогчийн бие өөрийн хийсэн ажиглалт судалгаа, эрдэмтдийн хийсэн ажил тулгуурлан дундад үеийн Монгол хэлний том дурсгалт бичгийн нэг болох "Монголын нууц товчоо"г шинэчлэн галиглан хэвлэлд бэлтгэсэн юм.

Монголын өргөн олон уншигчдад зориулж, МОНУТО-г хуучин монгол хэлнээс орчин цагийн монгол хэлээр яруу сайхан буулгаж, хэдэн удаа нийтлүүлсэн академич Ц.Дамдинсүрэн багш "Монголын нууц товчоог олон үндэстний уран зохиолын нэрт дурсгалын бичгүүдтэй зэрэгцүүлэн тавьж, жишээлэн хэлэлцэж болно. Тэр эрт холын цагт монголын ард түмний потор уран үгийг холбож, түүхт их явдлыг найруулан бичих цэцэн билэгтэй, гэгээн боловсролтой хүмүүс байсан байна" гэж бичжээ.

МОНУТО-д тархай бутархай монголын жижиг аймгуудыг нэгтгэж, төвлөрсөн улс байгуулагдсан явдлыг бичихийн хамт, зэргэлдээ улс оронд халдан түрэмгийлж байсан чингис хааны догшин бурангуй үйл явдлыг ил тод хэлсэн байна. Тэр үеийн монголын язгуурт нар эрх ашгаа булаалдан, өөр зуураа хямран байлдаж байсан тухайг ч нуулгүй тод өгүүлсэн байна.

Тэртээ хойын цагт зохиогдсон МОНУТО-г пэлхийн олон орны эрдэмтэн сонирхон судалж, орос, англи, франц, герман, хятад, япон, чех , польш, казах, унгар зэрэг хэлээр орчуулан нийтэлжээ.

Монгол аршын оюун билгийн энэ томхон бүтээлийг судлахад оросын эрдэмтэн П.Кафаров, А.М.Позднеева, зөвлөлтийн эрдэмтэн С.А.Козин , Б.Я.Владимирцов, германы эрдэмтэн Э.Хэниш, францын эрдэмтэн П.Пеллио, А.Мостер, чехословакийн эрдэмтэн П.Поуха, японы эрдэмтэн Нака Митиё, Ширатори Куракими, Токашира, Кобаяси, Ивамура, Ш.Хаттори, Унгарын эрдэмтэн Л.Лигети, польшийн эрдэмтэн С.Калужинский америкийн эрдэмтэн Ж.Стрит, австралийн эрдэмтэн Игорь де Рачевильц, монголын эрдэмтэн Ц.Дамдинсүрэн, М.Гаадамба, Х.Пэрлээ, Л.Маналжав нарын зэрэг олон арван эрдэмтэн өөрсдийн үр бүтээлт хөдөлмөрөө зориулсан юм.

Ш.Лувсанванчан багш Монголын нууц товчоог шинэчлэн галиглах нь зүйтэй болохыг "Уйгуржин монгол үсгийн цурсгалын зүйлийг галиглах тухай асуудал" гэсэн өгүүлэлдээ тэмдэглэсэн.

МОНУТО-ны судлалыг цаашид хөгжүүлэх, ялангуяа манай орны эрдэмтэн сэхээтэн нараас өөрийн арц түмний эрт оюоогийн түүх, соёлын олон асуудлыг сонирхон судлах явдал өсөн нэмэгдэж байгаа учраас МОНУТО-ны эх бичгийг нийтэлж, тэдний хүртээл болгох нь чухал билээ.

Бид МОНУТО-ны судалгааны галигийг хэвлэлд бэлтгэхдээ Э.Хэниш, П.Пеллио, Ширатори, К., С.А.Козин, Л.Лигети, И.Рачевильц нарын бүрэн галиг, Куо-ийн Пао-гийн 20 зүйлийн сийрүүлэг эдгээрийг хооронд нь нэг бүрчлэн тулгаж, Е.Дэхүй, Ширатори, Б.И.Панкратов нарын нийтлүүлсэн хятад үсгийн эхтэй нийлүүлэн шүүж, зөрүүтэй үг үсгийг илүү зөв гэж үзсэнээрэ шинэчлэн галиглав. Монголч эрдэмтэн нараас сүүлийн зуу гаруй жилийн дотор МОНУТО-г судлах талаар хийсэн арвин их бүтээлийг анхаарч үзэв.Дундад эртний үеийн монгол хэлний цурсгал бичгүүдийг харьцуулан судалж, шинжилгээний үнэт бүтээл туурвисан эрдэмтдийн ажил шүгнэлтэд тулгуурлан, МОНУТО зохиогдсон үеийн монгол хэлний авианы байдлыг үнэнд ойр болгож үзүүлэхийг чармайсан билээ.

Хятадын эрдэмтэн Е.Дэхүйн хоёр гал хуудас оршил бичиж, 1908 онд Нанжин хотноо пармаллуулсан 12 бүлэгтэй, 6 дэвтэр МОНУТО-ны хятад үсгийн эхийг үндэс болгож энэхүү галигийг гаргав.Эрдэм шинжилгээний зорилгоор ашиглах явдлыг хөнгөвчилж, системтэй болгохын тулд МОНУТО-ны бүлэг, зүйл, мөр бүрийг цугаарлав.

Е Дехүйн хэвлүүлсэн эхийн мөрийн тоог үнцсэнц нь хэвээр үлдээв.

Бицний гарт байгаа МОНУТО-ны эх бичиг нь нарийн нягт боловсруулсан авианы үсгээр бичигдээгүй, хятадын утга үсгийг үеийн үсгийн байдалтай авч ашиглан, монгол үгийг буулган тэмдэглэсэн учир I3-р зууны үеийн монгол хэлний авианы байдлыг нарийвчлан тусгаж гаргахад хялбар бус байсан нь ойлгомжтой.МОНУТО-ны галигийг олон улсац хэвлэн гаргасан боловч авч хэрэглэсэн галиг үсгийн систем нь бүрэн тогтоогүй, аргачилал нь зөрүүтэй байна.Жоч Стрит үүнийг ажиглаж тэмдэглэсэн зүйл бий.

МОНУТО-ны хэцэн янзын галигаас жишээ авч үзье. ЗЗІО-р мөр, Э.Хэниш ...

Э.Хэниш	... ekit ano dalberu mufus ano ba'utala ...
Ширатори	... ekid an-u dalburu mürüs an-u bayutala ...
П.Пеллио	... äkil anu dalbaru murus anu ba'utala ...
Л.Лигети	ekit anu dalbaru mürüs anu ba'utala ...
С.А.Козин	ekit ano dalbaru murus ano bautala ...
Куй-йи ПАО	e-ki-d a-nu da-l-ba-ru mu-ru-s a-nu ba-u-ta-la ...
Рачевильц	ekit anu dalbaru mürüs anu ba'utala ...

Зарим судлагч МОНУТО-ны хэлэнц хоёр гийгүүлэгчийн завсрын эгшиг орхигдож урт эгшиг бий болж байсан гэж тэмдэглэсэн зүйл нилээц бий.Бицний үзэж байгаагаар үүнээс гаднa бас тэр цагт нэгэнт байсан урт эгшгийг бичигт тэмдэглэх арга бий болж байжээ. гэж үзэлтэй санагдав.МОНУТО-ны I09-р мөрт,qarčiγaj-baan /合安/ гэцгийн цагаврын урт -хятадын цүрс үсгээр ба+ба=баан гэж тэмдэглэсэн нь сонирхолтой юм.Бид үүнийг баган > ба'ан > ба' ан>баан болсон гэж үзэхгүй байна.Энэ бол хятадын цүрс үсгийг ашиглах бололцоонц захирагдан, бан гэцгийг тэмдэглэсэн хэрэг гэж болож байна.Мөн тэнц -цан гэцгийг ца+ан=цаан /桑安/ гэжээ.МОНУТО-ц байгаа цагаан, гэгээн, өчүүхэн гэх мэт үгийн 2-р үеийн -аа-,-ээ-,-үү- нь бүр I3-р зууны үец нэгэнт урт эгшиг байсныг баримт харуулж байна.МОНУТО-ны цотор уйгуржин монгол бичгийн маягаар цагаан гэхийг 296. 454. 2245. 2385-р мөрц чаган, гэгээн

гэхийг I4II-р мөрд тэгэн, өчүүхэн гэхийг 145, 638, 954, I2I4, 2825-р мөрд үчүкэн гэж бичсэн болович 525, 2871, 2922, 3404-р мөрд чагаан, 82, 396, 2405-р гэгээн, 3I6, II39, I2I7, 2I69-д үчүүкэн гэж бичжээ.Мөн I879-д ацуучи, I873 -ацуучин, I065-д ацулагугай, I050, I05I, I054-д ацуулаху гэж бий.

Энэ хэлэн жишээнээс үзвэл, энэ нь хоёр эгшгийн завсрын гийгүүлэгч гээгдэж урт эгшиг бий болсон гэх нь эргэлзээтэй бөгөөд харин урт -а-г -ага-, урт -э-г -эгэ-, урт ү-г -үгү- гэж ярианы урт эгшгийг тэмдэглэж байсан гэж болно.Хожмын цагт монгол хэлэнд орсон гадаад хэлний урт буюу урт мэт хэлэгддэг эгшгийг мөн тогтсон тэр аргаараа уртасган бичдэг билээ.Жишээ нь:

маалинга гэхийг магалинга, таар гэхийг тагар, ваар гэхийг вагар, Японы эрдэмтэн Ш.Хаттори хятад үсгээр буулгасан МОНУТО-д урт эгшгийг тэмдэглэх хандлага байсныг ажигласан байлээ.

МОНУТО-ны бүх галигийг зэрэгцүүлэн үзэж, тэдгээрийн цуцаас нэгдмэл чанарыг агуулсан, эртний болон цуцад эртний монгол хэлний авианы тогтолцоог аль болох ойролцоо гаргасан галиг тогтоох боломж байгаа юм.Ер нь МОНУТО-ны галигийг зөв тогтоовол монгол хэлний тэр үеийн байдлаас гадна орчин цагийн монгол хэлний түүхэн хөгжлийг гүнзгийрүүлэн судлах хүмүүст ямар нэг хэмжээгээр тус дөхөм үзүүлэх нь дамжиггүй. МОНУТО-ны потор хадгалагдаж байгаа монгол хэлний баялаг материалыг судлан, авиан зүй, үг зүй, өгүүлбэр зүй, үгсийн сан, найруулга зүйн талаар харьцуулан дүгнэх, зарим маргаантай асуудлыг нэг мөр болгон үзэхэд их тус болох нь лавтай.

Монголын нууц товчооны шинэчилсэн галигаас жишээ авч үзүүлбэл:

2. 80. 448. temüjin siγūy dotora γurban qonoju γarsu kegen mori-ijān

449. kötöjü aγisugūy-dur morin-āsā emeē/l/ inū mülturejū

450. gočorču/γ/u qarīju uǰe/b/ēsü emeē/l/ kömüldürgelegseēr